



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 12 өдөр

Дугаар АА18

Булган сум

### Эм зүйчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, 2025 оны VI дугаар хуралдааны “Эрүүл Булган хөтөлбөр батлах тухай” VI/32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Дэлхийн эм зүйчдийн өдөр”-ийн хүрээнд эм зүйн салбарын мэргэжилтэн, ажилчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор зохион байгуулах сургалтын хөтөлбөрийг 1 дүгээр, сургалтад зарцуулагдах зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эм зүйчдийн ёс зүй, харилцаа хандлагын мэдлэгийг сайжруулах сургалтыг үр дүнтэй, чанартай зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн газар (П.Оюунцэцэг)-т даалгасугай.


3. Дээрх сургалтад зарцуулагдах 1,953,560 (нэг сая есөн зуун тавин гурван мянга таван зуун жаран) төгрөгийг “Эрүүл мэнд” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР


Аймгийн Засаг даргын 2025 оны  
 11 дүгээр сарын 12-ны/ний өдрийн  
 А/116 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



**ЭМ ЗҮЙЧДИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ  
 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

д/д	Сэдэв	Хугацаа	Зохион байгуулагч
1	2	3	4
<b>2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр</b>			
1	Бүртгэл, сургалтын өмнөх сорил	09:00-09:30	Зохион байгуулагч
2	Байгууллагын эерэг имижд, нөлөөлөх хүчин зүйлс	09:30-10:30	Сургагч багш Х.Өлзийжаргал
3	Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд эм зүйн мэргэжилтний оролцоо	10:30-11:40	Сургагч багш Д.Мөнх-эрдэнэ
4	Иргэдэд сургалт явуулах боломжит хэлбэрүүд	11:40-12:30	
Цайны завсарлага 12:30-14:00			
5	Хиймэл оюун ухаан ба эм зүйн мэргэжилтэн	14:00 -15:00	Сургагч багш Б.Хулан
6	Ургамлын гаралтай эмийн хэлбэрүүдийн хэрэглээ, гаж нөлөө, зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд анхаарах асуудал	15:00-16:30	Сургагч багш Д.Мөнх-эрдэнэ
7	Эмийн сангийн өрөлт, хураалт мерчандайзингийн 9 зарчим	16:30-17:30	Сургагч багш Х.Өлзийжаргал
<b>2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр</b>			
1	Эмийн сангийн хог хаягдал, гэрийн эмийн санг цэгцлэх	09:00-10:00	Сургагч багш Д.Мөнх-эрдэнэ
2	Албан ба албан бус харилцааг тэнцвэржүүлэх арга зүй	10:00-11:00	Сургагч багш Б.Хулан
3	Ажлаас халшрах, залхах, ажлын идэвхийг үнэлэх тодорхойлох, даван туулах арга зүй	11:00-12:30	Сургагч багш Б.Хулан
Цайны завсарлага 12:30-14:00			
4	GOOGLE FORM зохиох, холбох, түгээх, QR код үүсгэх үндсэн алхмууд, зарим цэс, тэдгээрийг ашиглах /иргэдээс авах сэтгэл ханамжийн судалгаа/	14:00-15:00	Сургагч багш Д.Мөнх-эрдэнэ
5	GOOGLE FORM ашиглан үүсгэсэн асуумжийн үр дүнгийн хүснэгт үүсгэх, үнэлэх /иргэдээс авах сэтгэл ханамжийн судалгаа/	15:00-16:00	
6	Үйлчлүүлэгчийн зан төлөв, эмийн зохистой хэрэглээнд нөлөөлөх нь	16:00-17:00	Сургагч багш Б.Хулан
7	Хаалт, сургалтын дараах сорил	17:00-17:30	Багш нар

Аймгийн Засаг даргын 2025 оны  
11 дүгээр сарын 12-ны/ний өдрийн  
А.А.Б. дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**БАГИЙН ЭМЧ НАРЫГ ЧАДВАРЖУУЛАХ СУРГАЛТЫН ТӨСӨВ**

д/д	Шаардлагатай зардал	Хэмжих нэгж	Тоо	Үнэ (төгрөг)	
				Нэг бүр	Нийт
1	2	3	4	5	6
1	Багш гарын машины шатахуун /900км/	Литр	198	2720	538,560
2	Зочид буудал	Хүн.хоног	3	180,000	540,000
3	Багш нарын хоол	Ш	9	25,000	225,000
4	Сургалтын цай	Ш	100	6500	650,000
	<b>Нийт</b>				<b>1,953,560</b>

--o0o--